

**“БАГАХАНГАЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК-ИЙН
ХҮНИЙ НӨӨЦИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ЧИГЛЭЛЭЭР
ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ**

2025 оны 10 дугаар сарын 10

Багахангай дүүрэг

НЭГ. ЕРӨНХИЙ ҮНДЭСЛЭЛ

“Багахангайн Үйлдвэрлэл, Технологийн Парк” ХК нь хүний нөөцийн удирдлагад ил тод, шударга, хариуцлагатай зарчмыг баримтлан ажиллаж, төрийн өмчит компанийн засаглалын сайн туршлагыг хэрэгжүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Хүний нөөцийн ил тод байдлыг хангах нь ажилтан бүр тэгш боломж эдлэх, хууль ёсны эрх ашиг нь хамгаалагдах, байгууллагын дотоод итгэлцэл, тогтвортой байдлыг бэхжүүлэх чухал нөхцөл гэж үзэн дараах арга хэмжээг хэрэгжүүлж байна.

**ХОЁР. ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР
ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ**

2.1. Хүний нөөцийн бодлого, журамтай холбоотой ил тод байдал

- Хүний нөөцийн бодлого, холбогдох журам, зааврыг батлуулан мөрдүүлж, ажилтнуудад танилцуулах
- Ажилд авах, шилжүүлэх, чөлөөлөхтэй холбоотой шийдвэрийг хууль тогтоомжийн хүрээнд гаргах
- Ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн баталж, ажилтан бүрт албан ёсоор хүргэх

2.2. Сонгон шалгаруулалт, томилгооны ил тод байдал

- Сул орон тоо гарсан тохиолдолд нээлттэй зарлан мэдээлэх
- Сонгон шалгаруулалтыг ил тод, шударга зарчмаар зохион байгуулах
- Дотоод нөөц бололцоонд тулгуурлан шатлан дэвших боломжийг бүрдүүлэх

2.3. Гүйцэтгэлийн үнэлгээ, урамшууллын ил тод байдал

- Ажилтны гүйцэтгэлийг бодит шалгуур үзүүлэлтэд тулгуурлан үнэлэх
- Гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнг ажилтанд танилцуулж, санал солилцох
- Ажлын үр дүнтэй уялдсан урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх

2.4. Сургалт, хөгжлийн ил тод байдал

- Сургалтын хэрэгцээг ил тод тодорхойлох
- Сургалтад хамрагдах ажилтныг шударга шалгуураар сонгох
- Сургалтын үр дүнг үнэлж, ажилтанд мэдээлэх

2.5. Хөдөлмөрийн харилцаа, мэдээллийн ил тод байдал

- Хөдөлмөрийн гэрээ, эрх үүргийн талаар ажилтанд бүрэн мэдээлэл өгөх
- Хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах
- Ажилтны санал, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх сувгийг нээлттэй байлгах

ГУРАВ. ҮР ДҮН, АЧ ХОЛБОГДОЛ

Дээрх арга хэмжээг хэрэгжүүлснээр:

- Хүний нөөцийн удирдлагын ил тод байдал хангагдана
- Ажилтнуудын итгэл, сэтгэл ханамж нэмэгдэнэ
- Хууль зөрчих эрсдэл буурна
- Байгууллагын засаглал, нэр хүнд сайжирна

БОЛОВСРУУЛСАН
ЗАХИРГАА, САНХҮҮ, УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.ОЮУНТӨГС